



БАЯНТАЛ СУМЫН 14 ХОНОГИЙН МЭДЭЭ 2022.04.11-04.25



Удирдлага зохион байгуулалтын ажлын хүрээнд:

-2022.04.21-22-ны өдрүүдэд хөдөөгийн малчдаараа явж хаваржилтын цагийн байдалтай танилцаж, малчидтай уулзаж, Мал амьтаны Гоц Халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх, малын дархлаажуулалтын ажлын зөвлөмж өгч, үүрэг чиглэл өглөө.


-**АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИСС ХУРАЛДЛАА./2022.04.23/** Онцгой комиссын 02 тогтоол, Хүнс Хөдөө Аж Ахуй, Хөнгөн үйлдвэрийн Сайдын 01 албан даалгаврын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд ХХААХҮ-ийн Дэд Сайд Г.Батсууриар ахлуулсан ажлын хэсэг Говьсүмбэр аймгийн онцгой комиссын гишүүдтэй уулзаж, мал амьтны гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх, малын дархлаажуулалтын ажлын талаар онцгой комиссын гишүүдэд зөвлөмж өгч, үүрэг чиглэл өглөө.





Удирдлага зохион байгуулалтын ажлын хүрээнд:

Сумын ИТХурлаас ирүүлсэн “Бэлчээр хамгаалах журам”-ын цахим хувилбар, нөлөөллийн шинжилгээний тайланг 2022.04.19-ны өдөр хүргүүлсэн.



- Сум хөгжүүлэх сангийн 2020-2021 оны баримтуудад Аймгийн ХХААГ-ийн дотоод аудитад орж, шаардлагатай мэдээлэл, тайлбарыг гаргаж хүргүүлсэн.
- Сум хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн 2 зээлдэгчийн асуудлыг шийдвэрлүүлэхээр Говьсүмбэр аймаг дахь Сум дундын Иргэний Анхан шатны шүүхэд өгсөн.





Малын гоц халдвар

Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцин, тандалт хяналт шалгалт судалгаа:

2929 толгой үхэр хамрагдахаас одоогийн байдлаар 28 өрхийн 1080 мал хамрагдаж 36,7 хувьтай явж байна.

Шүлхий өвчний тандалт хяналт шалгалтын талаар 4-р сарын 21-22-ны өдрүүдэд сумын нутаг дэвсгэрээр 373 км явж 25 айл өрхөөр орж хаваржилт, цаг үеийн байдалтай танилцаж шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх гарын авлагаар хангаж ажилласан. Мөн хөдөөгийн айл өрхөөр явахдаа отор нүүдэл оруулахгүй бэлчээр чөлөөлөх, бэлчээрийн мэрэгч огтоно тархалтын байдлын судалгааг хийсэн.

Сумын 1-р багийн нутаг Тэрэгтийн тал, Мөнх толгой, 2-р багийн Шилийн хутгийн зүүн талаар огтоны тархалт ихэссээр байна.

Энэ онд суманд отор нүүдэлээр ирсэн аймаг сумын малчид өвөлжөөгүй, өвөлжилт хаваржилт өнөтэй сайхан орж малын хорогдол гараагүй сэг зэм үүсээгүй байна



Шуурхай иргэ хэмээх ахуйн хэсэг

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.12, 59.1.23, 66 дугаар зүйлийн 66.1 Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.2, Улсын онцгой комиссын 02 дугаар "Малын гоц халдварт шүлхий өвчний нөхцөл байдлаа үнэлгээ хийх тухай" тогтоол, Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2022 оны 01 дүгээр албан даалгаврыг тус тус үндэслэн ЗАХИРАМКЛАХ нь:

1. Сумын хэмжээнд малын гоц халдварт шүлхий өвчин гарсан үед цаг үеийн хойшлуулашгүй шуурхай арга хэмжээг авч хэрэгжүүлж ажиллах ажлын хэсгийн дараах бүрэлдэхүүнтэй томилогуй.

Ажлын хэсгийн дарга:

Гишүүд:

Нарийн бичгий дарга:

Э.Эрхэмбаатар (Засаг даргын орлогч)
Н.Мөнхтүвшин (1 дүгээр багийн Засаг дарга)
Т.Ган-Эрдэнэ (2 дугаар багийн Засаг дарга)
М.Өмнөсүрэн (Мал эмнэлгийн мэргэжилтэн)
Х.Пүрэвжаргал (Цагдаагийн хэсгийн Төлөөлөгч)

2. Малын гоц халдварт өвчний цагийн байдлаар холбогдсон мэдээ мэдээллийг тухай бүрт танилцуулж ажиллахыг ажлын хэсгийн дарга (Э.Эрхэмбаатар)-д үүрэг болгосугай.

3. Малын гоц халдварт шүлхий өвчний үед ажиллахад шаардагдах төсвийн тооцог гаргаж бэлэн байдлыг хангах ажиллахыг (Ажлын хэсэг)-т үүрэг болгосугай.



©: My Documents/2022 4/14/2022 doc

421220084





Худалдан авах ажиллагааны хүрээнд:

Худалдан авах ажиллагаа: Цахим тендер

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх, 2 харьцуулалтын аргаар зохион байгуулах “Иргэдэд үйлчлэх цэгийн тоног төхөөрөмж, 154, 152-р байрнуудын урд болон хажуу тал автомашины зосгоол хийх” тендерүүдийг 2022 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр нээлт хийсэн боловч тендерүүд амжилтгүй болсон. Үнэлгээний хорооны ажлын хэсэг хуралдаж 2022 оны 04-р сарын 25-ны өдөр дахин зарлахаар шийдвэрлэв.

Худалдан авах ажиллагаа: Шууд худалдан авалт

Санхүүжилт:
ОНХСан

Ажил:
Золбин
нохой, муур
устгах

Гүйцэтгэгч:
Б.Буд

Гүйцэтгэл:
48 ш нохой
устгасан

Гэрээний дүн:
960,000 төгрөг





Удирдлага зохион байгуулалтын ажлын хүрээнд:

Худалдан авах ажиллагаа: Дуудлага худалдаа

Засаг даргын Тамгын газарт бүртгэлтэй LEXUS 470 автомашины дуудлага худалдаагаар зарах ажлын хэсгийг 2022 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн А/07 дугаар тушаалаар батлав. Ажлын хэсэг нь дуудлага худалдааг 2022 оны 05 дугаар сарын 20-ны өдөр зохион байгуулахаар ажиллаж байна. дуудлага худалдааны доод үнэ 6,500,000 төгрөг. Дэнчин нь үнийн дүнгийн 25% байхаар шийдвэрлэсэн.

ДУУДЛАГЫН ХУДАЛДААНЫ ЗАР МЭДЭЭ

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн Хурлын 2021 оны 37-р тогтоолын дагуу LEXUS 470, 00-03 ГСА улсын дугаартай авто машиныг нээлттэй дуудлага худалдаагаар худалдана.

1. Дуудлага худалдааны ерөнхий мэдээлэл

Дуудлага худалдааны хэлбэр	Нээлттэй
Гэрээний зүйл	Үйлдвэрлэсэн он: 2002 LEXUS 470, 00-03 ГСА улсын дугаартай суудлын автомашин
Дуудлага худалдаа болох хугацаа	2022 оны 05 дугаар сарын 20-ний өдрийн 15.00 цагт
Дуудлага худалдаа болох газар	Говьсүмбэр аймгийн Баянтал сумын Засаг даргын Тамгын газрын Иргэний танхимд
Худалдах доод үнэ	6,500,000 (Зургаан сая таван зуун мянга) төгрөг
Дуудлага худалдаанд тавих дэнчингийн хэмжээ	Худалдах доод үнийн дүнгийн 25 хувь буюу 1,625,000 (нэг сая зургаан зуун хорин таван мянга) төгрөг
Ялсан этгээдийг тогтоох журам	Үнэ хаялцан ялагч нь хамгийн өндөр үнэ санал болгосон этгээд байна.
Худалдах, худалдан авах гэрээний ерөнхий нөхцөл	Гэрээг ажлын 3 хоногийн дотор байгуулна. Худалдан авагч нь дуудлага худалдаагаар худалдан авсан эд хөрөнгийн үнийг 14 хоногийн дотор төлнө.
Дэнчинг байршуулах данс	Дуудлага худалдаа болох өдөр дэнчинг бэлнээр байршуулна.

2. Дуудлага худалдаанд хүсэлт ирүүлэх, оролцогчийг бүртгэх

Дуудлагын худалдаанд оролцох хүсэлтэй хүмүүс 2022 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 10⁰⁰-14⁰⁰ цаг хүртэл Говьсүмбэр аймгийн Баянтал сумын Засаг даргын Тамгын газрын иргэний танхимд хүсэлтээ ирүүлж бүртгүүлнэ. Хугацаа хоцорсон хүсэлтийг хүлээн авч бүртгэх, үнэ хаялцуулах ажиллагаанд оролцох боломжгүйг анхаарна уу.

3. Худалдах хөрөнгийн талаар мэдээлэл авах
Дуудлагаар худалдах хөрөнгийг өмч эзэмшигч Баянтал сумын Засаг даргын Тамгын газар буюу Баянтал сум 1-р баг залуучууд 203 байр хаягаар очиж үзэж болох бөгөөд хөрөнгийн талаарх мэдээллийг 99283341 утсаар авна уу.



Хөдөө аж ахуйн ажлын хүрээнд:

МАЛ ТӨЛӨЛТ, ТӨЛ БОЙЖИЛТЫН МЭДЭЭ

2022 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн байдлаар:

Нэр	Төллөх эх мал	Төлөлсөн эх мал	Хүлээн авсан төл						Төллөлтийн хувь	Бойжилтын хувь
Баянтал сум	26232	11065	19021						72,5%	100%
			Ботго-3	Унага-7	Тугал-32	Хурга-10629	Ишиг-8470	Ихэрлэлт-88		

Үүнээс хурга 77 ихэр, ишиг 43 ихэр, нийт ихэр 120 толгой



ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ, ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭ:

Хүнсний цахим эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагдаж байгаа 5 өрхийн 30 хүнд Хишиг Баян Уул ХХК-ны Баяндэлгэрэх дэлгүүрээс нийт 328,000 төгрөгний үнэ бүхийн хүнсний 10 нэр төрлийн барааг хугацаанд нь олгосон.

4 р сараас эхлэн Ахмад настны хөнгөлөлт тусламжийн үйлчилгээ, халамж цахим үйлчилгээнд шилжлээ. ХАБАЭ-н сарын ажлын нээлтэнд сумын ХАБЭА-н зөвлөл дарга, гишүүд болон ОНӨҮГ-ын удирдлага зэрэг 4 хүн оролцсон.





Коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд:

2022 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн байдлаар 9 өвчтөн байна. Эрүүл мэндийн төвд их цэвэрлэгээг 3 удаа хийж ариутгалын бодисоор ариутгасан

- Вепатит вакцинд- 3
- Товлолт дархлаажуулалтанд-6 хүүхэд
- 4-р тунгийн вакцинд- 2 иргэн
- Амбулторын үзлэг -14 иргэн хамрагдсан
- Хэвтэж эмчлүүлж байгаа -13 иргэн
- Ковид бүртгэгдээгүй, Ойрын хавьтал байхгүй
- PCR шинжилгээ- 0 иргэн
- Түргэвчилсэн шинжилгээ-2 иргэн
- Алсын дуудлага-3 иргэн
- Төвийн дуудлага-4 иргэн



Боловсрол, соёл урлагийн байгууллагуудын онцлох үйл явдалууд:

ЕБСургууль:

Говьсүмбэр аймгийн Ерөнхий боловсролын суургуулиудын ажилчдын дунд жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг Нөхөрсөг уулзалт Спорт, урлагийн тэмцээн уралдаанд амжилттай оролцон гар бөмбөгийн төрөлд 3-р байр, дуэт дууны төрөлд 2-р байр, буухиа төрөлд 2-р байрыг тус тус эзэлсэн.

Аймгийн аварга шалгаруулах хөнгөн атлетикийн тэмцээнд манай сургуулийн сурагчид амжилттай оролцож 1500м-ийн зайд эрэгтэй төрөлд 9а ангийн сурагч Олныхүү 1-р байр алтан медаль, эмэгтэй төрөлд 7а ангийн сурагч Хүслэн 3-р байр, Бөөрөнцөг шидэлтийн тэмцээнд 7а ангийн сурагч Баярцэцэг 2-р байр мөнгөн медаль тус тус хүртсэн

сургууль нь тусгай хрэгэцээт сурагчдын танхимыг өөрсдийн нөөц бололцоогоор засварлан тохижуулж ажиллагаанд оруулан ажиллаж байна. Тус үйл ажиллагааг дэмжих зорилгоор сумын Засаг даргын зөвлөл нь тусгай хэрэгцээт сурагчдын танхимд нэн шаардлагатай байсан 32 Инчийн LCD зурагтыг шийдвэрлэн өглөө.

СӨБоловсрол:

- Цэцэрлэгийн сургалт үйл ажиллагаанд ардын ёс заншлаас суралцуулах зорилгоор 3 бүлгийн 45 хүүхдэд ардын тоглоом Алаг мэлхий, Морь уралдах, шагай няслах тоглоомыг сурган, багш нар нээлттэй хичээлийг сар бүр зохион байгуулж багш, туслах багш нарын ур чадварыг сайжруулах ажлыг зохион байгуулан ажиллаж байна.
- Цэцэрлэгийн багш ажилчдын дунд чадавхжуулах сургалтыг 7 хоног бүр дотооддоо зохион байгуулсан..

Соёлын Төв:

- Соёл урлагийн арга хэмжээ-1, сургалт, тайлант хурал-1, нийт 2 арга хэмжээг техник хэрэгслээр ханган хамтран ажилласан.





Онцлох үйл явдалууд:

-Ерөнхий Сайдын санаачилсан “Илүүдэл жингүй-Эртэч монгол” аяны хүрээнд 2022 оны 04 дүгээр сарын 16 ний бямба гариг 5 байгууллагын 11 авто машинтай 54 хүний бүрэлдэхүүнтэй Чойрын богд ууланд нутгийн түүх, соёлын дурсгалт газруудтай танилцаж, байгууллагуудын албан хаагчдыг идэвхижүүлэх, эрүүл амьдралын зөв дадлыг бий болгох зорилгоор аялал, арга хэмжээ, нийтийн дасгал хөдөлгөөнийг зохион байгууллаа.

-2022 оны 4-р сарын 15-ний өдөр Боловсролын тусгай хэрэгцээ шаардлагатай байгаа хүүхдүүдийн хувийн ялгаатай байдал, хэрэгцээнд тулгуурлан боловсрол эзэмшүүлэх үйл явц ба нийгэмд хүлээн зөвшөөрөгдөх мөн тэднийг ялгаварлан гадуурхалыг зогсоож тэгш хамруулалтыг бий болгох багш, эцэг эх, иргэд хамтын ажиллагааг сайжруулах, санаа бодлоо солилцох зорилгоор Засаг даргын тамгын газрын иргэний танхимд 4-р сургууль, 4-р цэцэрлэг, Засаг даргын тамгын газар хамтран сургалт зохион байгуулж, Л.Отгонпүрэв, Б.Золзаяа, Б.Гандиймаа нар сургалт хийж мэдээлэл өглөө.

Уг сургалтад байгууллагуудын эцэг эхийн зөвлөл, сургууль, цэцэрлэгийн эцэг эхийн зөвлөл, иргэдийн төлөөлөл гээд 35 хүн хамрагдсан ба сургалтын нээлтийг Л.Гантөгс багшийн шавь нар 7-р ангийн сурагчид морин хуурийн татлага, Цэцэрлэгийн бэлтгэл бүлгийн хүүхдүүд “Цэцэрлэг минь сайн байна уу” дуугаар ая дуугаа өргөлөө.





Онцлох үйл явдалууд:

ХАРИЛЦАГЧАА СОНСОЁ

-Төрийн Аудитийн газраас **ХАРИЛЦАГЧАА СОНСОЁ** уулзалт болж санхүүгийн үйл ажиллагаанд ашигладдаг хууль тогтоомжийн эмхэтгэл, Төрийн Аудитийн байгууллагын үйл ажиллагааны талаар танилцуулга хийсэн байна.

-Хууль зүйн яамны харьяа Говьсүмбэр аймаг дахь хэлтэс агентлагууд болон аймгийн Гэмт Хэргээс Урьдчилан Сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн гишүүн байгууллагуудын дунд 4 сарын 16 ны өдөр зохион байгуулагдсан шилжин явах цомын спортын олон төрөлт тэмцээнд манай сумаас оролцсон баг тамирчид амжилттай оролцож гар бөмбөгийн төрөлд алтан медал, дардсны тэмцээнд мөнгөн медаль авч амжилттай оролцлоо.

-Цаг агаарын урьдчилсан мэдээг сумын иргэд, малчин айл өрхүүдэд цахимаар болон утсаар 3-5 удаа мэдэгдэж сэрэмжлүүлэн ажиллаж байна.

-"Газрын харилцааны-Цахим шилжилт" нээлттэй хаалганы өдөрлөгийг 2022 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр Баянтал сумын Засаг даргын Тамгын газрын Иргэний танхимд зохион байгуулав.

- "Усны ашиг тус" төрийн албан хаагч нарт эрүүл мэндийн сургалтыг зохион байгуулсан.





АНХААРАЛ ХАНДУУЛСАН ТАНД БАЯРЛАЛАА